

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Баяннуур сумын төсөвт байгууллагуудын 2017 оны
үйл ажиллагааны үр дүн**

**ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД
ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫГ ХАНГАЛТГҮЙ
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.**

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга бөгөөд тэргүүлэх аудитор М. Хуанган</p> <p>Аудитын менежер Х.Женисбек</p> <p>Ахлах аудитор Х.Манаргүл</p> <p>Аудитор Б.Үүрийнтуяа</p> <p>Аудитор У.Ербол</p> <p>2018 оны 11 дүгээр сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930, 70422954 дугаарын утсаар харилцана уу</p> <p>ХАЯГ:</p> <p>Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар</p>	<p>Товчилсон үгийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4</p> <p>Бүлэг 1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажилласан байна.</p> <p>1.1. <i>Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэл муутай төлөвлөсөн байна</i> 5-6 1.2. <i>Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд нөлөөлсөн байна.</i>6-8</p> <p>Бүлэг 2.Төсөвт байгууллагууд орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.</p> <p>2.1.1. <i>ИТХ цалингийн сангийн хэмнэлтийг зориулалтын бус зарцуулсан байна</i>9 2.1.2. <i>ЗДТГ батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна</i>.....9 2.2.1. <i>Бүрэн дунд сургууль төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна</i>..... 10-12 2.2.2. <i>Цагаан арал бага сургууль батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна</i>..... 12-13 2.2.3. <i>Цэцэгт бага сургуулийн анги дүүргэлт нормт хэмжээнд хүрээгүй, байна</i>..... 13-15 2.2.4. <i>Хүүхдийн цэцэрлэг батлагдсан орон тооны хязгаарыг баримтлаагүй, хоолны зардлын нормыг мөрдөж ажиллаагүй байна</i>..... 15-16 2.2.5. <i>Соёлын төв батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ</i>..... 16. 2.2.6. <i>Эрүүл мэндийн төв батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна</i>..... 16-17.</p> <p>Бүлэг 3. Дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.</p> <p>3.1. <i>Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна</i>..... 18-20</p> <p>3.2. <i>Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн биелэлтийг хангаж ажилласан байна</i>.....20</p> <p>Дүгнэлт.....21</p> <p>Зөвлөмж.....22</p> <p>Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал ... 23</p> <p>Саналд өгсөн тайлбар</p>
--	--

Товчилсон үгийн тайлбар

АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УЗ	Удирдах зөвлөл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БДС	Бүрэн дунд сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн ИТХ-ын захиалгаар Баяннуур сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал, зөвлөмж гаргаж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэх, дүнг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго оршив.

Хамарсан хүрээ

Гүйцэтгэлийн аудитад Баяннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Бүрэн дунд сургууль, Цагаан арал бага сургууль, Цэцэгт бага сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн 2017 оны үйл ажиллагааг бүрэн хамруулж, ажлын болон санхүүгийн тайлан, санхүүгийн баримт материалд үндэслэн аудитыг хэрэгжүүлэв.

Төрийн сангийн үйл ажиллагаа, Орон нутгийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад энэ оны 9-11 дүгээр сард Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар аудит хийгдсэн болно.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, санхүүгийн тайлан, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглав.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг ахлах аудитор Х.Манаргүл ахалж, аудитор Б.Үүрийнтуяа, У.Ербол нарын нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хуваарийн дагуу хийж хэрэгжүүлэв. Аудитын баг 2018 оны 11 дүгээр сарын 12-ноос 12 сарын 19-ны хооронд ажиллаж, аудитын дүнг урьдчилсан байдлаар танилцуулж, аудитын тайланг 12 дугаар сарын 10-наас бэлтгэв.

Бүлэг 1

*Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг
29,4 хувиар давуулан биелүүлсэн байна.*

Оршил

Баяннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 онд урсгал зардалд нийтдээ 3066,0 сая төгрөгийн төсөв батлагдсаны 2494,4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 342,9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 55,9 сая төгрөгийг ОНХСангаас, 111,7 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 61,1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тусгагджээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 2490,5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 342,9 сая төгрөгийн, ОНХСангаас 55,9 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 63,2 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 54,7 сая төгрөг бүрдүүлж, нийтдээ 3003,7 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс 62,3 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ. Энэ нь Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төлөвлөсөн орлого бүрдээгүйтэй холбоотой байна.

Орон нутгийн төсөвт байгууллагуудад 28,5 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 30 орон тоо ажиллуулж 1,5 орон тоо, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд 224 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 242 орон тоогоор ажиллуулж 18 орон тоог хэтрүүлэн ажиллуулсан байна.

Орон нутгийн захиргааны байгууллагууд 376,2 сая төгрөгийн, Тусгай зориулалтын шилжүүлгийг байгууллагууд 2491,8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ.

Төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагаанаас 1,6 сая төгрөгийн орлого оруулахаас 1,1 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 0,5 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

Аудитын явцад сумын иргэдээс 10 өргөдөл хүсэлт ирснээс 3 өргөдөл, 2 иргэний амаар өгсөн хүсэлтийг шалгаж хариуг газар дээр нь өгсөн, 1 өргөдлийг буцааж авч, 4 өргөдлийг завсрын аудитаар шалгаж хариуг өгөхөөр шийдвэрлэсэн болно. Мөн Мэргэжлийн хяналтын газраас манайд шилжүүлсэн Бүрэн дунд сургуулийн багш нарын өргөдлийг шалгаж, хариуг багш нарт танилцуулсан.

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажилласан байна.

1.1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэл муутай төлөвлөсөн байна.

Сумын ИТХ-аас 2017 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 21,7 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 Орлогын төрөл	2016 он		2017 он		/сая төгрөг/ Зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
А.Урсгал орлого	18.1	24.2	21.7	3.6	- 2.6	
I.Татварын орлого	18.1	22.3	21.6	3.5	- 0.7	
1.Орлогын албан татвар	8.5	11.6	12.2	3.7	0.6	
1.1 ХАОАТатвар	8.5	11.6	12.2	3.7	0.6	
Хувиара аж ахуй эрхэлсний орлогын татвар	8.5	11.6	12.2	3.7	0.6	
2.Өмчийн татвар	2.3	2.2	3.0	0.7	0.8	
Бууны албан татвар	2.3	2.2	3.0	0.7	0.8	
4.Бусад татвар	7.3	8.5	6.4	- 0.9	- 2.1	
Улсын тэмдэгтийн хураамж	1.8	1.8	1.9	0.1	0.1	
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	4.9	1.6	3.5	- 1.4	1.9	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.6	5.1	1.0	0.4	- 4.1	
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	-	1.9	0.1	0.1	- 1.9	
Хөрөнгө борлуулсаны орлого		1.9	0.1	0.1	- 1.9	

Эх сурвалж: Баяннуур сумын 2016, 2017 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Нийт орлогын 56,2 хувийг ХАОАТатвараас, 13,8 хувийг өмчийн татвараас, 29,8 хувийг бусад татвараас, 0,2 хувийг хөрөнгийн орлогоос оруулахаар төлөвлөжээ.

2017 оны орлогын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулахад нийт дүнгээр 3,6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орлогыг нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 3,7 сая төгрөгөөр, өмчийн татвар 0,7 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 0,1 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад татвар 0,9 сая төгрөгөөр буурсан байна.

Харин өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад нийт дүнгээр 2,6 сая төгрөгөөр буурч батлагджээ.

Орлогын нэр төрлөөр авч үзвэл ХАОАТатвар 0,6 сая төгрөгөөр, өмчийн татвар 0,8 сая төгрөг нэмэгдэж, бусад татвар 2,1 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 1,9 сая төгрөгөөр буурсан байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд 2017 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө үндэслэл муутай хийгдсэн байна.

1.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд нөлөөлсөн байна.

Сумын 2017 оны орон нутгийн төсвийн орлогоос 28,1 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 6,4 сая төгрөгөөр буюу 29,4 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 94,7 хувийг татварын орлогоос, 5,3 хувийг татварын бус орлогоос бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2	/сая төгрөг/			
	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
А.Урсгал орлого	21,7	28,1	6,4	129.4
I.Татварын орлого	21,7	26,6	4,9	122.7
1.Орлогын албан татвар	12,2	13,3	1,1	108.9
1.1 ХАОАТатвар	12,2	13,3	1,1	108.9
Хувиара аж ахуй эрхэлсний орлогын татвар	12,2	13,3	1,1	108.9
2.Өмчийн татвар	3.0	2,3	-0,7	76.3
Бууны албан татвар	3.0	2,3	- 0,7	76.3
4.Бусад татвар	6,5	11,0	4,5	170.1
Улсын тэмдэгтийн хураамж	1,9	1,1	- 0,8	59.0
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	3,5	2,0	- 1,5	57.2
Ус ашигласны төлбөр		0,2	0,2	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,0	7,6	6,6	760
II.Татварын бус орлого	-	1,5	1,5	
2.2 Хүү, торгуулийн орлого		1,4	1,4	
2.5 Бусад нэр заагдаагүй орлого		0,1	0,1	

Эх сурвалж: Баяннуур сумын 2017 оны орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

Гүйцэтгэлээр нийт орлогын 47,3 хувийг ХАОАТатвараас, 8,3 хувийг өмчийн татвараас, 39,2 хувийг бусад татвараас, 5,5 хувийг хүү, торгуулийн болон бусад нэр заагдаагүй орлогоос оруулжээ. 2017 оны гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 5,7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ХАОАТатварыг 8,9 хувиар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 6 дахин давуулан биелүүлж, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 23,7-43,8 хувиар тасарчээ.

Сумын нутаг дэвсгэрээс барагшуун түүх тухай сумын засаг даргын захирамж гарч хэрэгжүүлсэн нь орон нутгийн төсвийн орлого нэмэгдэж, төлөвлөгөө давж биелэхэд нөлөөлсөн байна.

Аймгаас тус сумын ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 3,5 сая төгрөгөөр баталсан нь төлөвлөгөө тасрахад нөлөөлжээ. Аймгийн Сум дундын Ойн ангиас сумын байгаль хамгаалагчдад 840 м3 буюу 2,0 сая төгрөгийн түлээ мод бэлтгэх эрхийн бичгийн зөвшөөрөл өгснийг биелүүлж, төлбөрийг дансанд бүрэн төвлөрүүлсэн байна.

Сумын татварын байцаагчаас ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх талаар сумын ИТХурал, ИТХурлын тэргүүлэгч, Засаг даргад ажлын тайлан тавихдаа үндэслэл тооцоог танилцуулж ажилласан боловч төлөвлөгөөг жил бүр илүү баталж ирсэн байна.

Цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансаар 141.9 сая төгрөгийн, газрын төлбөрөөс 1.3 сая төгрөгийн, үл хөдлөх хөрөнгийн талбан татвараас 0,5 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Сумын Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 6,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 28,1 сая төгрөгийн орлого оруулж, 21,7 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 3,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумын ИТХурлын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор өмнөх оны орлогын давсан хэсэг болох 6,4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сумын удирдлагын зүгээс татвар хураалтад хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажилласан байна. Тухайлбал: бууны албан татварыг сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгчтэй хамтран хураан барагдуулах арга хэмжээ авч, багуудаар явж татвар хураахад бензин шатахуун өгч туслалцаа дэмжлэг үзүүлсэн байна.

Тайлант онд орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх нөөц бололцоог ашиглах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан нь төлөвлөгөөг нийт дүнгээр давж биелэхэд нөлөөлсөн боловч цаашид орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бүрэн биелүүлж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх нөөц бололцоог бүрэн ашиглах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 2

Төсөвт байгууллагууд орон тооны хязгаарыг баримталж ажиллаагүй байна.

2.1. Орон нутгийн захиргааны байгууллагуудаас 12,2 сая төгрөгийн зөрчил илэрчээ.

2.1.1. Сумын ИТХурал батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар 2016 оны 11 дүгээр сараас 2018 оны 3 дугаар сар хүртэл н.Гүлденген ажилласан ба 2018 оны 4 дүгээр сараас Шүүхийн шийдвэрээр Амантай нь ажилд орсон байна. ИТХ-ын 2017 оны ажлын тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Гүлденген нь ажлаа бүрэн хүлээлгэж өгөөгүй байгаа тул хурлын үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн талаар тайланд тусгах боломжгүй байна.

Сумын ИТХурлын 2017 оны үйл ажиллагаанд 46,5 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 46,5 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулан төсөвтөө багтаан үйл ажиллагаагаа явуулжээ.

Аудитын дүнгээр ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 34 дүгээр тогтоолоор цалингийн сангаас хэмнэгдсэн 1,0 сая төгрөгийг хурлын тэргүүлэгчид, Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарт урамшуулалд олгож, зориулалтын бус зарцуулсныг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2.1.2. Сумын Засаг даргын тамгын газар батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.

Сумын Засаг даргын тамгын газрын даргаар 2017 оны 1-8 дугаар сард М.Хонай, 9-12 дугаар сард П.Сатжол ажилласан ба 2018 оны 10 дугаар сараас Шүүхийн шийдвэрээр З.Мадениет нь ажилд орсон байна. ЗДТГ-ын 2017 оны ажлын тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг Тамгын газрын даргаар ажиллаж байсан хүмүүс хүлээлгэж өгөөгүй байгаа тул байгууллагын үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн талаар тайланд тусгах боломжгүй байна.

Засаг даргын тамгын газар нь 2017 оны урсгал зардалд 329,7 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ.

Цалин, тээвэр шатахууны зардлын батлагдсан төсвийг 10,2 сая төгрөгөөр хэтрүүлж, санхүүгийн тайланд өглөгөөр харуулсан байна.

Хүнс хөдөө аж ахуйн газраас царцаатай тэмцэх зардалд 5,1 сая төгрөгийн, малын вакцины санхүүжилтэд 16,2 сая төгрөгийн, Статистикийн хэлтсээс мал

тооллогын зардалд 0,8 сая төгрөгийн, бүгд 22,1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч, нэмэлт санхүүжилтийн дансаар санхүүгийн баримтуудыг бүрдүүлэн зарцуулсан байна.

Сумын Засаг даргын 2017 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн Б/46 дугаар захирамжаар ЗДТГ-ын бүтэц орон тоог шинэчлэн тогтоож 2017 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн архив бичиг хэргийн эрхлэгчийн орон тооноос гадна архив хариуцсан үйлчлэх ажилтны орон тоог шинээр бий болгож ажиллуулан, цалинг ТҮ-5-1 дэх шатлалаар цалинжуулсан байна. Дээрх архив хариуцсан үйлчлэх ажилтны цалинг ТҮ-5-1 ангилал зэрэглэлээр тогтоож, 2017 оны 6 дугаар сараас 2018 оны 8 дугаар сард нийт 0,9 төгрөгийн цалинг илүү олгож ирснийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.2, 16.5.3, 16.5.5, 41.2.2, Засгийн газрын 2007 оны 354 тогтоолын 7 хавсралт, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр ЗДТГ-т 0,9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10,2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2.2. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.

2.2.1. Бүрэн дунд сургууль төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Бүрэн дунд сургууль нь 2017-2018 оны хичээлийн жилд 38 бүлэг, 958 суралцагч, дотуур байранд 238 хүүхдийг хамруулан үйл ажиллагаа явуулжээ. Хичээлийн жилд бага ангид 396 сурагч, дунд ангид 249 сурагч, ахлах ангид 313 сурагч хамрагдаж, үйл ажиллагаагаа явуулжээ.

Сургуулийн орон тооны хязгаарыг 130 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 75, үйлчлэх 45, гэрээт 14 нийт 135 орон тоог цалингийн санд багтаан ажиллуулсан байна.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Сумын засаг дарга, сургуулийн захирал гурвалсан гэрээ байгуулан ажиллаж, 3 бүлгийн 64 төрлийн ажил төлөвлөж, 2017 оны Үр дүнгийн гэрээний биелэлтээр 80.8 хувь буюу “хангалттай” үнэлгээ авсан байна.

Бүрэн дунд сургууль нь 2017 онд 1427,5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэгээр 1427,5 сая төгрөгийн санхүүжилт авч, 1423,7 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 3,8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн 71,6 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 3,6 хувийг тогтмол зардал, 1,2 хувийг хангамж бараа материалын зардал, 6,6 хувийг норматив зардал, 0,2 хувийг эд хогшил худалдан авах зардал, 16,1 хувийг урсгал шилжүүлэг, 0,7 хувийг бусад зардал эзэлж байна.

Бичиг хэргийн зардал, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж зэрэг зардлуудыг 0,04-3,8 сая төгрөгөөр хэмнэжээ.

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 919,9 сая төгрөгийн төсөв батлагдсаныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Ахлах сургуулийн орон тооны хязгаарыг 130 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр 135 орон тоо ажиллуулж орон тоог 5 хүнээр хэтрүүлж, цалингийн санд багтаан ажиллуулсан байна.

Үдийн цай хөтөлбөрт 36,3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1-5 дугаар ангийн 16 бүлгийн 387 сурагчийг хамруулж, 36,0 сая төгрөгийн төсөв зарцуулсан байна.

Үдийн цайны бүтээгдэхүүнийг “Ну орман” ХХК, “Цул улаан” ХХК, “Ахсын тас” ХХК, Цэцэгт Мараа зэрэг аж ахуйн нэгжүүд гэрээний дагуу нийлүүлжээ. Үдийн цайд хамрагдаж буй анги бүлгийн хүүхдийн тоог өдөр бүр бүртгэж, бүртгэлийг үндэслэн үдийн цай олгосон байна. Үдийн цайны нэг хүүхдэд ногдох нормыг Засгийн газрын тогтоолд заасан хэмжээнд хэрэгжүүлсэн байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 100 хувь, түлш халаалтын зардлын төсвийн 40 хувийг “Асылжан” ХХК гэрээний дагуу гүйцэтгэжээ. Аудитын явцад гэрээний гүйцэтгэлд тооцоо хийж үзэхэд хоолны зардалд 3,8 сая төгрөгийг дутуу олгож, түлш халаалтын зардалд 3,4 сая төгрөгийг илүү олгосон байна. Тооцооны зөрүү 0,4 сая төгрөгийг “Асылжан” ХХК-д буцаан олгож, цаашид тооцоог гүйцэтгэлийн баримтыг үндэслэн сар бүр үнэн зөв хийж байхыг зөвлөв.

Сургуулийн түлшний зардлын төсвийн 60 хувийг “Буршал” хоршоо гэрээний дагуу гүйцэтгэсэн ба жилийн эцсийн тооцоогоор үүссэн 2,1 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна. “Буршал” хоршооны эзэн шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхээс “Буршал” хоршооны буцаан олгох шийдвэр гаргасан байна.

Аудитын явцад Бүрэн дунд сургуулийн багш нарын 7 заалт бүхий өргөдлийг шалгаж, багш нарын хуралд өргөдлийн хариуг танилцуулсан.

Өргөдлийн дагуу цалингийн сангийн тооцоог шалгаж үзэхэд Боловсрол, соёл, урлагийн газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/14 тоот тушаалаар сургуулийн захиралд 0,6 сая төгрөгийн, сургуулийн захирлын 2017 оны 23, 33, 42, 43, 2018 оны 19, 23 дугаар тушаалуудаар 28 багшид 5,1 сая төгрөгийн зэрэг дэвийн нэмэгдэл, 2017 оны 40, 44, 2018 оны 22, 36, 44 дүгээр тушаалаар 10 багш, ажилчдад 1,7 сая төгрөгийн бүгд 7,4 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосныг нөхөн төлүүлж, зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 4, 5 дугаар заалтуудыг зөрчсөн байна.

Сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 214,0 сая төгрөгийн зөрчил илэрч акт, албан шаардлага өгөгдсөн бөгөөд гүйцэтгэлийн аудитаар давтан шалгаж үзэхэд:

Санхүүгийн тайлангийн аудитаар сургуулийн 2017 оны 3 дугаар сарын харилцахын баримтыг аудитад ирүүлээгүйгээс 94,1 сая төгрөгийн, жилийн эцэст тооллого хийсэн боловч тооцоог бодож, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй 112,8 сая төгрөгийн, бүгд 206,8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Сургуулийн 2017 оны төсвөөс 7,1 сая төгрөгийг хоёр компанид шилжүүлж, санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, үндэслэх анхан шатны баримтгүйгээр шууд зардлаар бүртгэж, тайланд тусгаж, төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсныг нөхөн төлүүлэхээр акт тогтоосныг 2018 онд барагдуулсан байна.

Аудитын явцад хичээлийн байр, дотуур байр, гал тогооны тохижилттой танилцаж үзэхэд үйл ажиллагаа нь хэвийн, зохих түвшинд хангагдсан байна.

Аудитын дүнгээр Бүрэн дунд сургуульд 7,4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2.2.2. Цагаан арал бага сургууль батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.

Цагаан арал бага сургууль нь 2016-2017 оны хичээлийн жилд 5 бүлэг, 90 суралцагч, дотуур байранд 50 хүүхдийг хамруулан 8 багш, 10 ажилчинтай үйл ажиллагаагаа явуулжээ.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Сумын засаг дарга, сургуулийн захирал гурвалсан гэрээ байгуулан ажиллаж, 6 бүлгийн 14 төрлийн ажил төлөвлөж, 2017 оны Үр дүнгийн гэрээний биелэлтээр 83,3 хувь буюу “хангалттай” үнэлгээ авсан байна.

Бага сургууль нь 2017 онд тусгай зориулалтын шилжүүлгээр 215,8 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ.

Бага сургуулийн 2 давхар хичээлийн байрны дээвэр салхинд нурж, үнэ тогтоох комиссын үнэлгээний акт тогтоолгож хоол, түлш халаалтын зардлын хэмнэлтээс 4,5 сая төгрөгийг холбогдох журмаар гүйлгэн зарцуулах зөвшөөрлийг авч, дээврийн засварыг хийлгэсэн байна.

Засгийн газрын 2008 оны 54 дүгээр тогтоолын дагуу багш, ажилчдын улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшил цалинд 6,4 сая төгрөгийн санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулжээ.

Үдийн цай хөтөлбөрт 8,7 сая төгрөгийн төсөв батлагдаж, 1-5 дугаар ангийн 5 бүлгийн 90 сурагч хамрагдаж, гүйцэтгэлээр 8,1 сая төгрөгийг үдийн цайнд, 0,6 сая төгрөгийг зайлшгүй шаардлагатай аяга таваг, сав суулга худалдан авахад зарцуулжээ. Үдийн цайнд хамрагдаж буй анги бүлгүүдийн хүүхдийн тоог өдөр бүр бүртгэж, бүртгэлийг үндэслэн нийлүүлэгчээс үдийн цайны бүтээгдэхүүнийг олгож, нэг хүүхдэд ногдох нормыг Засгийн газрын тогтоолд заасан хэмжээнд хэрэгжүүлсэн байна.

Тус бага сургуулийн орон тооны хязгаарыг аймгийн ИТХ-аас 18-аар хянаж баталсан ба гүйцэтгэлээр 19 орон тоо ажиллуулж, орон тоог 1-ээр хэтрүүлж, цалингийн сандаа багтаан ажилласан байна.

Байгууллагад хөтлөгдөх журнал, ерөнхий дэвтэр болон туслахуудыг тухай бүр хөтлөн, татварын болон НДШ-ийн тайлан, санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж, холбогдох газруудад хүргүүлж ажиллажээ.

Байгууллагын даргын тушаалаар батлагдсан тооллогын комисс жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Үйл ажиллагаанд зарцуулсан аж ахуйн материалыг шаардах хуудсаар, шатахууныг замын хуудсаар тооцоо хийж, зохих журмын дагуу зарлагад гаргасан байна.

Дотуур байрны хүүхдийн хоолонд 15,3 сая төгрөгийн хүнсний материалыг иргэд, аж ахуйн нэгжүүдээс худалдан авч, өдөр бүр талоны дагуу зарцуулалтын тооцоог хийж, тайлагнасан байна.

Дотуур байранд 1-4 дүгээр сард 2519 хүүхэд/өдөр, 9-12 дугаар сард 3891 хүүхэд/өдөр, нийт 6410 хүүхэд/өдөрт 15,7 сая төгрөгийн хүнсний материал зарцуулж, нэг хүүхдийн өдрийн хоолны дундаж зардалд 2445 төгрөг гарч байгаа нь хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормоос 130 төгрөгөөр хэтэрч 0,8 сая төгрөгийг илүү зарцуулсныг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 45.2.1 дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитын дүнгээр Цагаан арал бага сургуульд 0,8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

2.2.3. Цэцэгт бага сургуулийн анги дүүргэлт нормт хэмжээнд хүрээгүй байна.

2017-2018 оны хичээлийн жилд “Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, сурах таатай орчин бүрдүүлэх, хүүхэд бүрийг хөгжих боломжийг бүрдүүлэх, сурагчдын авьяасыг нээн илрүүлэх” гэсэн зорилго тавьж ажилласан байна.

“Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх” зорилтын хүрээнд хүүхэд бүрийн хэл ярианы хөгжилд судалгаа хийж түвшин тогтоож, судалгааны дүгнэлтэд тулгуурлан уралдаан тэмцээн зохион байгуулан, “Үлгэрийн баатар амилсан нь” сэдэвт тэмцээнийг бүлгүүдийн дунд зохион байгуулж, “Ном” хөтөлбөрийн хүрээнд сургуулийн удирдлагын дэмжлэгтэйгээр анги бүрийн номын сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, номын фондыг баяжуулах зорилгоор том жижиг ном хийх, номын богц аялуулах уралдаан зарлаж тэргүүн байр эзэлсэн бүлгийг урамшуулж, лхагва гариг бүрийн 14-16 цагт нийт сурагч, багш нар ном уншиж хэвшин, аймгийн төв номын сангаас зохион байгуулсан уран уншлагын уралдаанд амжилттай оролцож, аймгийн номын сангаас мэргэжилтнүүдийг урьж “Хүүхдийг номтой нөхөрлүүлэх” сэдэвт сургалт зохион байгуулан, “эцэг эхийн нэг өдөр” сэдэвт ажил зохион байгуулж эцэг эхчүүдтэй уулзалт хийсэн зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

Тус байгууллагаас удаа дараа шаардсан боловч үр дүнгийн гэрээ байгуулсан болон дүгнүүлсэн ямар нэгэн нотлох баримт ирүүлээгүй тул аймгийн БСУГазраас тодруулахад 2017 оны Цэцэгт бага сургуулийн захирлын БСУГазрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт 50 хувьтай үнэлэгдсэн талаар албан тоот ирүүлсэн байна.

Цэцэгт бага сургууль нь 2017 онд 132,4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, төсвийг бүрэн зарцуулж, өр авлагагүй гарсан байна.

Тус бага сургуулийн орон тооны хязгаарыг 11 хүнээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 5, үйлчлэх 5, гэрээт 1, нийт 12 орон тоог цалингийн санд багтаан ажиллуулсан байна. Цагийн багшийн 1 орон тоог ажиллуулжээ.

2017-2018 оны хичээлийн жилд 1-р бүлэгт 6 хүүхэд, 2-р бүлэгт 3 хүүхэд, 3-р бүлэгт 9 хүүхэд, 4-р бүлэгт 10 хүүхэд, 5- бүлэгт 6 хүүхэд нийт 5 бүлэгт 36 сурагчтай, дотуур байранд 19 хүүхэд амьдарсан байна.

Бага сургуулийн анги дүүргэлт нь БСШУСайд, НХХСайд, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 4-т “анги дүүргэлтийг бага ангид 30-35 /багийн салбар бүлэгт 20-оос доошгүй байхаар зохион байгуулна” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлээр хэтрэлт, хэмнэлт гаргаагүй боловч гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илрүүллээ. Үүнд:

- Хүнсний бараа материалын тайлангаар 3635 хүүхдэд 8,7 сая төгрөгийн материал зарцуулж, хүүхдийн нэг өдрийн хоолны дундаж зардалд 2386 төгрөг гарч, дотуур байрны хүүхдийн хоолны зардлын өдрийн нормыг 71 төгрөгөөр хэтрүүлж, 0,3 сая төгрөгийг илүү зарцуулсан.

- 2017 оны 4-р сарын аж ахуйн материалын тайлангаар 0,4 сая төгрөгийн материалыг үдийн цайнд зарцуулсан боловч үдийн цайны талонд захирал гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тайланг захирал, нягтлан бодогч нар хянаж гарын үсэг зураагүй.

- Цалин, урамшууллын зардал, тээвэр шатахуун, цахилгааны зардлаас 0,3 сая төгрөгийг аймгийн Төрийн сангаас зохих зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан, захирлын цохолт бичгээр 0,2 сая төгрөгийн шатахуун авч хэрэглэсэн боловч шатахууны тооцоог хийж баримтжуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй.

- 2017 оны 1 дүгээр улирлын урамшуулалд бүх хүмүүст 20%-иар тооцож 1,2 сая төгрөг, 2 дугаар улирлын урамшуулалд 18%-иар тооцож 1,1 сая төгрөг, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 20%-иар тооцож 1,4 сая төгрөг, нийт 3,8 сая төгрөгийг ажиллагсдын ажлыг бодитой дүгнэхгүйгээр хавтгайруулан олгосон, нярав М.Сонгыбект ажлын үр дүнг дүгнэхгүйгээр захирлын тушаалаар 0,7 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Дээрхи зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1,16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.4, 20.2 дах хэсгийн 20.2.5, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.1, 7.2-ийн 7.2.3, Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоолоор баталсан" Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшил олгох журам"-ын 2.1, 2.2,2.3, 2.4, 2.5, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" журмын 3, Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тоот хамтарсан тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох тухай журам"-ын 5, 6, 7 дах заалтуудыг тус тус зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөв.

Иргэн Б.Оналганд шуудан холбооны зардлаас олгосон 0,5 сая төгрөг, К.Байболатад олгосон 0,1 сая төгрөг, хоолны зардлаас шилжүүлсэн 0,1 сая төгрөг, гэрэл цахилгааны зардлаас шилжүүлсэн 0,07 сая төгрөг, бүгд 0,3 сая төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар шилжүүлж, шууд зардлаар бүртгэсэн, мөн түүнчлэн бага сургуулийн хэрэгцээнд 2017 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №06 дугаар зарлагын падаанаар 1,0 сая төгрөгийн нүүрс, бургас модыг зарцуулсан боловч тухайн сарын аж ахуйн бараа материалын тайланд 1,3 сая төгрөгийн нүүрс, бургас модыг зарлага гаргаж 0,3 сая төгрөгийг илүү тайлагнасан тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Аудитын дүнгээр Цэцэгт бага сургуульд 0,6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2.2.4. Хүүхдийн цэцэрлэг батлагдсан орон тооны хязгаар, хоолны зардлын нормыг мөрдөж ажиллаагүй байна.

Хүүхдийн цэцэрлэг нь 2017-2018 оны хичээлийн жилд "Хүүхэд нэг бүрийн өөрийн онцлог, чадвар бүтээлч үйлийг дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх" гэсэн зорилго дэвшүүлэн, цэцэрлэгийн үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг боловсролоо дээшлүүлэх, хууль тогтоомж стандарт ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, санхүүгийн болон эд хөрөнгийг зөв зохистой ашиглах зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч 2016 оны 10 дугаар сард аймгийн Засаг даргын захирамжаар чөлөөлөгдөж 2017 оны 7 дугаар сард шүүхийн шийдвэрээр эргүүлэн томилогдсон байна. 2017 онд үр дүнгийн гэрээ хийгдээгүй байна.

2017 оны санхүүгийн баримтад 1 дүгээр гарын үсгийг 01 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 25-ний хооронд эрхлэгч К.Саулегүл, 04 дүгээр сарын 25-наас 07 дугаар сарын 17-ны хооронд эрхлэгч Х.Алтангүл, 07 дугаар сарын 17-ноос хойш шүүхийн шийдвэрээр эргүүлэн томилогдсон эрхлэгч И.Айгүл, 2 дугаар гарын үсгийг 01 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 19-ны хооронд нягтлан бодогч Ш.Айнур, 10 дугаар сарын 20-ноос хойш нягтлан бодогч Ш.Гүлдана нар тус тус зурж, няраваар А.Жайна ажилласан байна.

2017 онд сумын төвийн цэцэрлэгт 5 бүлэг, 2, 3 дугаар багт салбар 2 бүлэг, бүгд 7 бүлэгт 175 хүүхэд /үүнээс салбар бүлэгт 40-50 хүүхэд/, хувилбарт сургалтаар 3 бүлэгт 80 хүүхдийг тус тус хамруулж, 33 багш, ажилчидтай үйл ажиллагаа явуулжээ.Цэцэрлэгийн багш, ажилчид, хүүхдүүдийн судалгааг боловсролын мэдээллийн системд оруулж, багш ажилчдын хувийн хэргийг зохих журмын дагуу бүрдүүлж, баяжуулалт хийж ажилласан байна.

Хүүхдийн цэцэрлэг нь 2017 онд 316,1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулсан ба 315,8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгээр, 0,3 сая төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлэхээр тусгагджээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэгээр 315,8 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулж, өөрийн орлогоос орлого ороогүй байна.

2017 оны орон тооны хязгаарыг 30 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 16, үйлчлэх 12, гэрээт 4, нийт 33 орон тоог цалингийн санд багтаан ажиллуулсан байна. Энэхүү илүү 3 орон тоо нь 2013 оноос ажиллаж байгаа орон тоо байна.

Хүнсний бараа материалын тайлангаар нийт 31585 хүүхдэд 54,6 сая төгрөгийн хүнсний материал зарцуулж, хүүхдийн хоолны зардлын нормыг 80 төгрөгөөр хэтрүүлж, нийтдээ 2,5 сая төгрөгийг илүү зарцуулсан, хоолны зардлаас нормын хувцас, аж ахуйн материал авахад 0,6 сая төгрөгийг зохих зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн зарцуулсан, Цэцэрлэгийн эрхлэгчийн цохолт бичгээр 2,0 сая төгрөгийн шатахуун авч хэрэглэсэн боловч шатахууны тооцоог хийж баримтжуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй, ХХОАТ-ын өрийг 0,8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн зөрчийг арилгуулах талаар албан шаардлага өгөв.

Аудитын дүнгээр Хүүхдийн цэцэрлэгт 5,9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2.2.5. Соёлын төв батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ.

Соёлын төв нь 2017 онд 7 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулжээ. Сумын Соёлын төв нь 2017 онд урлаг соёлын 108 төрлийн графикчилсан төлөвлөгөө гарган ажиллаж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулжээ.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, Соёлын төвийн эрхлэгч үр дүнгийн гэрээ байгуулж, үр дүнгийн гэрээний биелэлтээр 80,8 хувиар “хангалттай” үнэлгээ авчээ.

Соёлын төв нь тусгай зориулалтын шилжүүлгээр 51,7 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 1,3 төгрөгийн орлого оруулж нийт 52,9 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажилласан байна. Өөрийн орлогын төлөвлөгөөг 13,8 хувиар тасалдуулсан байна.

2.2.6. Эрүүл мэндийн төв батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.

Баяннуур сумын ЭМТөвийн эрхлэгч эмч сумын Засаг даргатай 2017 онд үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан боловч гэрээний биелэлтийг дүгнэж ажиллаагүй байна. Санхүүгийн баримтад 1 дүгээр гарын үсгийг эрхлэгч А.Бейбит, 2 дугаар гарын үсгийг оны 01 дүгээр сарын 01-нээс 08-р сарын 23-ны хооронд нягтлан бодогч К.Байболат, 08-р сарын 23-наас хойш нягтлан бодогч М.Хонай зурж ажилласан.

Эрүүл мэндийн төв нь 2017 оны 357,5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, тусгай зориулалтын шилжүүлгээс 351,1 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 6,4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Эрүүл мэндийн төвийн орон тооны хязгаарыг 28 хүнээр баталснаас гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 22, үйлчлэх 10, гэрээт 5, нийт 38 орон тоогоор жилийн эхнээс ажиллажээ. Орон тоо хэмнэх зорилгоор тухайн онд 2 хүнийг цомхотголд оруулж, 1 хүнийг ажлаас чөлөөлж, 35 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулжээ. Цагаан арал багийн салбарт 8 орон тоотой ажиллаж байгаа ба бага эмч 1, эх баригч 1, асрагч 3, сувилагч 2, галч 1 байна.

Эмийн сангийн сонгон шалгаруулалтад тэнцэж хөнгөлөлттэй эмээр үйлчлэх эрх авч 6,6 сая төгрөгийн санхүүжилт авч, Норвегийн эрүүл мэндийг дэмжих төслийн хүрээнд хүчилтөрөгчийн аппараттай болсон байна.

Эмнэлгийн барилгын чанарт аймгийн МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж, барилгын дээвэрт өөрсдийн нөөц бололцоогоор засвар хийсэн байна. Засварыг төрийн сангаас зөвшөөрөл авч халаалтын зардлын хэмнэлтээс санхүүжүүлсэн байна.

Аудитын явцад зарим бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тооллогын дүнтэй тулгаж үзэхэд зөрүү гараагүй болно. Гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

1. 2017 оны 03 дугаар сард “НИК” ХХК-д хог хаягдлын зардлаас 0,1 сая төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар шилжүүлж, шууд зардлаар бүртгэсэн, 3-р сарын аж ахуйн тайланд 0,09 сая төгрөгийн бараа материал орлогод авч төлбөрийн хүсэлтээр 0,1 сая төгрөг, 4-р сард 0,4 сая төгрөгийн нормын хувцас худалдан авч төлбөрийн хүсэлтээр 0,4 сая төгрөг, 5-р сард 0,6 сая төгрөгийн аж ахуйн материал худалдан авч 0,6 сая төгрөг шилжүүлж, нийт 0,1 сая төгрөгийг илүү тайлагнаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.4, 20.2 дах хэсгийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5 дах хэсгийн 16.5.5, 26 дугаар зүйлийн 26.1, 41 дүгээр зүйлийн 41.2 дах хэсгийн 41.2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн тул нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Аудитын дүнгээр Эрүүл мэндийн төвд 0,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Бүлэг 3

Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

3.1. Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 252,6 сая төгрөгийн зөрчлийн биелэлтийг хангаж ажилласан байна.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Бүрэн дунд сургууль, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, Засаг даргын тамгын газар, Цагаанарал БСургууль, Цэцэгт БСургууль, ОНХСан, Сум хөгжүүлэх сангийн жилийн эцсийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Сумын ИТХурал, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөсөн байна.

Аудитын үр дүнг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /сая. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс Зөрчилгүй санал дүгнэлт	/сая. төг/
				Хязгаарлалттай санал дүгнэлт
Бүрэн дунд сургууль	214,0	1		1
Цагаанарал БСургууль				
Цэцэгт БСургууль				
Эрүүл мэндийн төв	24,3	1		1
Хүүхдийн цэцэрлэг	7,4	1	1	
ЗДТГазар	1,9			
ТТЗ-ийн СНТ	5,0	1	1	
Дүн	252,6	4	2	2

Сумын Хүүхдийн цэцэрлэг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчилгүй, Бүрэн дунд сургууль, Эрүүл мэндийн төвд хязгаарлалттай санал дүгнэлт өгөгдсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар Бүрэн дунд сургуулиас 214,0 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвөөс 24,3 сая төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэгээс 7,4 сая төгрөгийн, ЗДТГазраас 1,9 сая төгрөгийн, СХСангаас 5,0 сая төгрөгийн, нийтдээ 252,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн.

Үүнээс 12,4 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, 240,2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөгдсөн ба гүйцэтгэлийн аудитаар биелэлтийг шалгахад албан шаардлагыг 100 хувь биелүүлж, актын барагдалт 94,4 хувьтай байна.

Орон нутгийн захиргааны байгууллагууд өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлж, жилийн эцэст хөрөнгийн тооллого, тооцоог хийж байгууллагад хөтлөгдвөл зохих журнал, ерөнхий дэвтэр болон туслахуудыг тухай бүр хөтлөн, татварын ба НДШ-ийн тайлан, байгууллагын тайлан тэнцлийг хугацаанд нь гаргаж зохих газарт нь хүргүүлж ажилласан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудаас Цэцэгт бага сургууль, Цагаан арал бага сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв зэрэг байгууллагууд өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад тавих дотоодын хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлж, жилийн эцэст үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Харин тусгай зориулалтын шилжүүлгийн зарим байгууллагууд нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Сургууль жилийн эцсийн тооллогын үр дүнгээр 112,8 сая төгрөгийн хөрөнгийн тооцоог бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. ЭМТөв нь тайлант онд нийтдээ 18,8 сая төгрөгийн шатахууныг орлого авч, зарлага гаргасан боловч, шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцож ажиллаагүй байна.
- Бүрэн дунд сургууль, ЭМТөв нь санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой материаллаг алдаа зөрчил илэрч хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад Бүрэн дунд сургуулийн захиралд, Сумын ЗДТГ-т Бүрэн дунд сургууль, Эрүүл мэндийн төвийг хариуцсан нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Үндэсний аудитын газрын аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Төрийн сангийн тогтолцоо, 2017 оны үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн аудитаар тус сумын Төрийн сан нь "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн 178,7 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага өгч, Сумын Засаг даргад санхүүгийн албаны дарга, төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн нарт хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитаар энэхүү сангуудын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс ОНХСанд 5,3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 66,8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, Сум хөгжүүлэх санд 30,2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 253,4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, Аймгийн Засаг даргад Сумын засаг даргад хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

Баяннуур сумын төсөвт байгууллагуудын 2017 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээр нийтдээ 32,9 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 3,6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 29,3 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

Тайлант онд Баяннуур сумын төсөвт байгууллагуудад хийсэн Санхүүгийн тайлангийн аудитаар болон Төрийн сангийн үйл ажиллагаа, ОНХС, СХСангийн 2017 оны хөрөнгийн зарцуулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит, Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийтдээ 3535,5 сая төгрөгийн зөрчил илэрч, үүнээс 51,5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3484,0 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдсөн байна.

3.2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

ИТХурал, ЗДТГазар, БДСургууль, Цагаан арал бага сургууль, Цэцэгт бага сургууль ЭМТөв, Хүүхдийн цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулж, шилэн дансны самбарыг байршуулсан байна.

Гүйцэтгэлийн аудитаар ИТХурал, ЗДТГазар, БДСургууль, Цэцэгт бага сургууль, ЭМТөв, Хүүхдийн цэцэрлэгийн шилэн дансны хэрэгжилтийг шалгаж үзэхэд төсвийн болон бусад холбогдох мэдээллийг байгууллагын шилэн дансны самбарт байршуулсан байна.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөгөөр 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар дээрх байгууллагууд шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн 2894,3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч биелэлтийг 2017 онд хангуулж ажилласан.

ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажилласан байна.

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэл муутай төлөвлөсөн байна.
2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд нөлөөлсөн байна.

2.Төсөвт байгууллагууд орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.

2.1. Орон нутгийн захиргааны байгууллагуудаас 12,2 сая төгрөгийн зөрчил илэрчээ.

1. ИТХ цалингийн сангийн хэмнэлтийг зориулалтын бус зарцуулсан байна.
2. ЗДТГ батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.

2.2. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.

3. Бүрэн дунд сургууль төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна
4. Цагаан арал бага сургууль батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.
5. Цэцэгт бага сургуулийн анги дүүргэлт нормт хэмжээнд хүрээгүй, байна.
6. Хүүхдийн цэцэрлэг батлагдсан орон тооны хязгаарыг баримтлаагүй, хоолны зардлын нормыг мөрдөж ажиллаагүй байна.
7. Соёлын төв батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ.
8. Эрүүл мэндийн төв батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллаагүй байна.

3. Дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

1. Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн биелэлтийг хангаж ажилласан байна

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмж өгөгдөөгүй байна.

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал



ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Х.МАНАРГҮЛ

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

АУДИТОР

У.ЕРБОЛ